

## ЦЭРГИЙН ҮЛЭЭВЭР ХӨГЖМИЙН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ

### III. Цогтгэрэл.

Батлан хамгаалахын их сургууль. Цэргийн хөгжмийн сургууль.

**Өгүүллийн товч утга:** Энэхүү өгүүлэлд үлээвэр хөгжмийг эрт дээр үеэс цэрэг дайны ажиглалаанд ашиглаж ирсэн тухай болон монгол оронд цэргийн гуулин үлээвэр хөгжим хэрхэн үүссэн, Богд хаант төрийн үеийн монголын сүлд дууллыг хэн зохиосон, үлээвэр найрал хөгжмийн монголын соёл урлагийн болон батлан хамгаалах салбарт гүйцэтгэж ирсэн үүрэг, түүний онцлог, ач холбогдолын талаар тодруулж түүхийн судалгааны чиглэлд тулгуурлан эрдэм шинжилгээ-судалгааны ажлын эргэлтэд оруулах зайлшгүй шаардлагатай байгааг баримтад түшиглэн өгүүлсэн болно.

**Түлхүүр үг.** Дуу хөгжим, цэрэг дайны хөгжим, төрийн дуулал, цэргийн үлээвэр хөгжим, Богд хаант төр, батлан хамгаалах салбар.

Монголчууд бидний дуу хөгжмийн соёл нь олон мянган жилийн түүхтэйг сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн баримтуудаас гадна гадаад дотоодын эрдэмтдийн бичсэн эрдэм шинжилгээний бүтээл, жуулчидын тэмдэглэл, дүрслэх урлагийн дурсгалууд, уртын дуу, шүлэг, яруу найраг гэх мэт олон зүйлээс мэдэж болно. Дуу хөгжимгүйгээр монголчуудын амьдралыг төсөөлөх аргагүй.

Монголчуудын эртний өвөг болох Хүннү нар олон торлийн хөгжмийн зэмсэг хэрэглэдэг байсны дотор үлээвэр хөгжмийн зэмсгийг хэрэглэж байсан тухай олон баримт түүхийн сурвалж бичиг, дүрслэх урлагийн бүтээлүүдэд үлдсэн байна. Жишээ нь, аргын тооллын өмнөх I зуунд Хятадын Хан улсын цэргийн эрхтэн Ли-Лин, Сүн-Ү гэдэг хоёр хүн хоорондоо захидлаар харилцсан тэмдэглэлд “Хүннү-д намар нь хүйтэн даарч байхад Хүннү цэргийн бүрээ хангинан адуу янцгаах нь сонсогдоно”-[1.6,7] гэжээ. Эндээс үзэхэд одоогоос хоёр мянган жилийн өмнө монголчууд үлээвэр хөгжмийн зэмсгийг хэрэглэж байсан нь тодорхой бөгөөд энэ бол манай хөгжмийн түүхийн тодорхой нэгэн баримт төдийгүй Хүннү цэргийн цугларалт, жагсаалд ч тэр үеийн үлээвэр хөгжим /бүрээ, дун...гэх мэт/ чухал үүрэг гүйцэтгэж ирсэний тод жишээ билээ.

Одоогоос олон зуун жилийн өмнө бидний өвөг дээдэс баяр ёслолын үед “өвдөг газрыг үлтэртэл” бүжиглэн хөгжимдөж, наадаж байсан тухай “Монголын нууц товчоо”-нд өгүүлсэн байдаг. Түүнчлэн дайн тулааны өмнө ч цэрэг эрсийн сэтгэл зоригийг чангалан, сүлд хийморийг сэргээх зорилгоор дуу дуулан, хоёр чавхдаст хөгжмөө татаж хөгжимдөн тулалдааныг хүлээдэг заншилтай байсан тухай дурьджээ. Байлдаан, тулалдааны ялалтаа ч мөн л дуу хөгжимтэй тэмдэглэж, туг сүлдээ тахиж татдаг эртний уламжлалтай.

Монгол Улсын төрийн соёрхолт, хөгжмийн зохиолч, доктор С.Соронзонболд “XIII зууны Монголын хөгжим” номондоо тэр үеийн хөгжмийн урлагийг:

- Төрийн ёслолын хөгжим
- Цэрэг дайны хөгжим
- Иргэний болон зан үйлийн хөгжим
- Бөө мөргөл болон шашны хөгжим гэсэн 4 төрөлд хуваагаад “Цэрэг дайны

хөгжим” монголчуудад олон зуун жилийн тэртээд ч байсан гэдгийг онцгойлон тэмдэглэжээ.

Хэдийгээр тэр цагийн “Цэрэг дайны хөгжим”-өөс шууд уламжлагдан хадгалагдаж үлдсэн зүйл үгүй ч дайн байлдаанд уухайлан хашгирч довтолгоонд ордог байсан уухай нь өнөөгийн бидний мэдэх ардын аман аялгууны нэгэн төрөл болох сурын болон шагайн уухайнд хадгалагдан үлдсэн гэж болно.

Тэгэхээр үлээвэр хөгжмийн зэмсэг, хэрэглэгдэхүүний тухай монголын дээд үс, аргын тооллын өмнөх үетэй холбон ярилцдаг нь зүй ёсны хэрэг юм. Ер нь XIII зууны үеэс хөгжмийн зэмсэг, хөгжмийн соёл нь монголд улам бүр боловсорч түүнийг цэрэг улс төрийн чухал хэрэгсэл болгохын зэрэгцээ, төрөл зүйлийг олшруулан ая дэгийг найруулж,

сүрлэг бөгөөд ихэмсэг шинжтэй болгон өөрчилжээ. Тэгэхдээ төрийн хурим ёслолын хүрээнд үлээвэр хөгжмийн зэмсэг чухал үүрэг гүйцэтгэж байсан нь тодорхой байдаг. Тухайлбал “Мөнх хааны 2-р онд /1252/ хааны зарлигаар тусгай хороо байгуулан хөгжимчний өмсөх ёслолын хувцас малгай хийгээд алтан хөөрөг ба хас туурганы өлгүүр, жагсаалын хэрэглэл зэргийг үйлдүүлж, сурагчдыг сурган боловсруулсан ба ...багласан бишгүүр, хас туурга, хөндлөн бишгүүр, шавар бишгүүр зэргийг барьж хааны өмнө гурав дахин хөгжимдөөд давшиж, дуулах хөгжмөөр дээд тэнгэрийг наран саран уулнаа тайжээ”- [2.21] гэж тэмдэглэсэн нь дээр өгүүлснийг нотлох бас нэгэн баримт.

Монголчуудын хөгжмийн урлагийн олон зууны туршид өвлөгдөж ирсэн уламжлалт уран бүтээл түүнийг туурвин бүтээх зарчим, суралцах дэг сургууль, түгээн дэлгэрүүлэх хэлбэр, тэр ч бүү хэл гоо сайхны таашаал сонирхол нь суурин соёл иргэншилтэй улс орны хөгжмийн соёлын тогтсон хэв загвар, сэтгэлгээнээс нилээд өөр. Энэ нь Төв Азийн өргөн уудам нутагт хэдэн мянган жилийн турш нүүдлийн мал аж ахуй эрхлэн, жилийн дөрвөн улиралд нүүдэллэн нутаглаж, аж төрж ирсэн малчин монголчуудын амьдрах хэв маяг, аж төрөх ёс, зан заншил, сэтгэл зүй, байгаль газар зүйн орчин, цаг уурын онцлог гэх мэт олон хүчин зүйлсээс хамааралтай юм.

Монголын урлаг соёлын энэ гайхамшигт бүхэн, өвөрмөц ёс заншилаа даган өнөөдрийг хүртэл хадгалагдаж ирсэн ч XX зууны эхэн үеэс суурин соёл иргэншилтэй өрнөдийн улс орнуудад үүсэж бий болсон, дэлхийн сонгодог урлагийн олон төрлүүд манай оронд нэвтэрч эхэлсэн билээ. Ингэснээр бид хүн төрөлхтөний оюуны их соёлын нэгээхэн хэсгийг хүртэж, түүгээрээ бахархаж, түүнээс таашаал авах болжээ.

Цэргийн гуулин үлээвэр хөгжим монголд нэвтэрсэн нь. 1911-1912 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд Монгол түмэн Манжийн эрхшээлээс ангижирч тусгаар тогтносон үеэс Монгол оронд хаант Оросоор дамжин дэвшилттэй шинэ зүйлүүд, түүний дотор Оросын соёл, шинжлэх ухааны нөлөө ололтууд нэвтэрч, Европын хөгжмийн урлаг манай оронд дэлгэрэх анхны алхам тавигдсан билээ. Өөрөөр хэлбэл 1911 онд Богд Жавзандамба болон Монголын нөлөө бүхий том ноёд Монгол улсаа Манжаас тусгаарлах арга сүвэгчлэн Хаант Оросоос тусламж эрэх бичиг сэлт үйлдэн, Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, түшмэл Хайсан нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг 7 дугаар сарын сүүлчээр Санктпетербург-т илгээж өрнө зүгээс албан ёсоор тусламж гуйсан нь улс төрийн үйл ажиллагаа боловч нөгөө талаас нь авч үзвэл өрнөдийн соёл иргэншлийг хүлээн зөвшөөрсөн баримт гэж үзэж болох бөгөөд түүний нөлөөгөөр манай оронд өрнөдийн соёл урлаг хөгжих анхны алхам тавигдсан гэж болно.

Монголын засгийн газрын ерөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэн тэргүүтэй бүрэн эрхт төлөөлөгчид 1913-1914 оны зааг үеэр Хаант Орос улсад айлчилж Монгол Улсын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд баталгаажуулах, монгол туургатны нилээд хэсгийг багтаасан Монгол Улс байгуулахыг Хаант Орос улсаар зөвшөөрүүлэх, зээл, зэвсэг авах зорилгоор айлчлал хийсэн. Т.Намнансүрэн Орос улсад хандан нилээд хэмжээний зэр зэвсэг тухайлбал, винтов буу, үхэр буу, сум... зэргийг өгөхийг хүссэн ба түүнд Хаант Оросын ерөнхий сайд шууд шийдтэй хариу өгөхөөс татгалзаж “Би танайхыг их улс болох болтугай гэж ерөөхгүй, бас бид таныг ямар ч байсан хоосон буцаахгүй” гэжээ. Ингээд тодорхой хугацаагаар хүлээлгэсний эцэст хаант Орос улсаас буу зэвсэг болон тодорхой хэмжээний мөнгөн тусламж /рублийн зээл/ олгох болж түүний зарцуулалтанд хяналт тавих Оросын талын түшмэлийг Нийслэл хүрээнд суулгах гэрээ хийсэн байна [3. 29].

Оросууд гэрээ хэлцэлд тусгагдсан зүйлүүдийг хүлээлгэж өгөхдөө үлээвэр хөгжим эгшиглүүлэн ёслол төгөлдөр зохион байгуулсан бөгөөд энэ хөгжмөөр эгшиглэх цог золбоотой аялгуунд сэтгэл хөдөлсөн Сайн ноён хан Т.Намнансүрэн бараа болж явсан Хаант Оросын ноёд, албаны хүмүүст хандан “Зэр зэвсэг өгөхдөө ийм цэргийн үлээвэр хөгжимтэй байвал сайнсан” гэсэн утга бүхий үг цухуйлгажээ. Тэр ёсоор ч хаант Оросоос зэр зэвсэгтэй цуг цэргийн үлээвэр хөгжим Монголд ирсэн гэдэг [4.145].

Энэ түүх үнэн гэдгийг “Монголын засгийн газар хаант Орос улсын засгийн газартай хэлэлцээр хийж Орос улс Монголд 5 төрлийн 8-10 тооны хөгжмийн зэмсэг оролцуулан тусгай бэлэг өгч, 1914 оны 11-р сард Богд хааны бие хамгаалах торгон цэргийн бүрэлдэхүүнд 9 хүний орон тоотой цэргийн үлээвэр найрал хөгжмийн салаа байгуулагджээ” [5.33] гэсэн баримт баталж байна.

Ингэж хоёр улсын засгийн газрын хооронд хийсэн гэрээ, хэлэлцээр амжилттай болж, Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн хүсэлтээр Монголын засгийн газарт үлээвэр хөгжмөөр бэлэг барьснаар Монгол Улсад орчин цагийн цэргийн үлээвэр хөгжим үүсэн бий болох материаллаг боломж бүрджээ.

Энэ бол Европ дахины оюуны хөгжлийн их ололт болсон үлээвэр найрал хөгжмийг монголын ард түмэнд танилцуулж эхэлсэн анхны алхам байв.

Үүнээс үзэхэд Монгол Улсын цэрэг Богд хаант улсын үеэс өөрийн гэсэн цэргийн үлээвэр хөгжимтэй байж, тэр нь төр, цэргийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд үүрэг гүйцэтгэх болжээ. Ийнхүү үлээвэр найрал хөгжим Монгол оронд бий болсон явдал Монголын ард түмний үндэсний дуу хөгжмийн урлагийн хөгжилд нэгэн том алхам болсон төдийгүй үндэснийхээ хөгжмийн соёлыг урагш хөгжүүлэхэд чухал түлхэц болсон юм. Тухайлбал, манай оронд үлээвэр хөгжмийн анхны хамтлаг бий болсноор өрнийн сонгодог хөгжмийн урлаг Монгол үндэстний урлагт нөлөөгөө өгч цаашид хөгжин дэвжих үндэс суурь нь тавигджээ.

“Зуун лангийн жороо луус”-Богд хаант төрийн сүлд дуу. Олноо өргөгдсөн Богд хаант Монгол Улсыг байгуулсны дараа тусгаар тогтнолын хийгээд төрийн бэлэгдлийг цогцлоон бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тулгарсан бөгөөд тэдгээрийн нэг нь өөрийн сүлд дуутай болох явдал байв.

Оросын хөгжмийн зохиолч, Марины театрын тэргүүлэх хөгжимчин Андрей Вячеславич Кадлецид монгол аялгуугаар Монголын үндэсний Сүлд дууг бичих захиалга эгчээ. А.В.Кадлец уг ажлыг гүйцэтгэхдээ монголчуудын дунд ихэд тархсан байсан “Зуун лангийн жороо луус” гэдэг монгол дууны аяыг сонгон авч ноотлон, үлээвэр найрал хөгжимд тоглоход зориулсан найруулга хийж өгсөн байна. Түүний найруулсан “Зуун лангийн жороо луус” дуу нь Богд хаант төрийн үед /1914-1921 онд/ Монгол улсын төрийн дуулал болж төр шашны хүндэтгэлийн үйл ажиллагаа болон олны цуглааны үед эгшиглэх болжээ. (Жич: А.В.Кадлецийн энэхүү гавъяа зүтгэлийг Богд хаан зохих ёсоор үнэлж “Эрдэнийн очир” одонгоор шагнасан байна) [6.22,25].

Энэхүү баримтуудаас үзвэл монгол үндэсний сүлд дуу нь анх үлээвэр найрал хөгжимд зориулагдан бичигдэж Богдын торгон цэргийн үлээвэр найрал хөгжимчид 1914 оны намраас /10, 11-р сараас/ анх эгшиглүүлж олны сонорт хүргэсэн гэж үзэж болохоор байна.

Энэ нь монголын дуу хөгжмийн түүхэнд гарч ирсэн цоо шинэ үйл явдал, монгол хөгжмийн урлагийг Европын хөг аялгууны зарчмаар баяжуулан бадруулах анхны алхамыг үлээвэр хөгжмөөр тавьсан эхлэл байв.

Тиймээс Монгол Улс сүлд дуутай болсон энэ үеэс орчин цагийн монголын цэргийн үлээвэр хөгжмийн үүсэл эхэлсэн гэж үзэх үндэстэй юм.

Цэргийн үлээвэр хөгжмийн хөгжлийн тойм Цэргийн үлээвэр найрал хөгжим үүсэж хөгжөөд хүн төрөлхтөний урлаг соёлын сонгодог гайхамшгийг монгол нутагт түгээн дэлгэрүүлж, монгол түмнийхээ оюуны мэлмийг баясган цэнгүүлсээр 100-аад жилийн нүүрийг үзсэн ч эдүгээ орчин цагийн Монголын цэргийн хөгжмийн үүсэл хөгжил, түүний түүхэн замналыг судлан тодорхойлсон судалгааны бүтээл, ном, сурах бичиг одоог хүртэл хараахан гараагүй, орчин цагийн цэргийн үлээвэр хөгжмийн “төрсөн өдөр”-ийг ч яг таг тогтоон баталгаажуулаагүй байгаа билээ.

“Монгол үндэсний хөгжмийн урлагт дэлхийн олон улсын хөгжмийн урлаг нөлөөлж... манай билэг төгөлдөр хөгжмийн зохиолчдын уран хөдөлмөрийн утгыг махбодьжуулж, уянгыг сэтгэлд халдацтай яруу сайхан болгож байна. Европын хөгжмөөс Монголд

## II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

нэвтрэн ирж, манай нөхцөлд идээшин өрнөж байгаа хөгжмийн хамгийн ууган нь үлээвэр найрал хөгжим юм” гэж эрдэмтэн түүхч Х.Пэрлээ “Соёл, утга зохиол сэтгүүлийн 1964 оны дугаар 9-д “Манай шинэ хөгжмийн соёлыг судлах юм биш үү?” гэсэн гарчигтай нийтлэлдээ бичсэн буй.

Үнэхээр ч дэлхийн олон улсын хөгжмийн урлагаас анх түрүүнд манай оронд нэвтрч, монголын хөгжмийн урлагийн бүхий л салбарт тодорхой үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ Монгол Улсын Батлан хамгаалах салбарт бие даасан үүрэг гүйцэтгэж ирсэн цэргийн үлээвэр хөгжим нь хөгжмийн бусад төрлүүдээс ялгагдах онцлогтой юм.

2004 онд Монгол Улсад өрнийн сонгодог үлээвэр хөгжим үүсч хөгжсөний 90 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэж Цэргийн үлээвэр найрал хөгжмийн үүслийг орчин цагийн Монголын хөгжмийн урлагийн үүсэлтэй зэрэгцүүлж, XX зууны эхэн үе, тэгэхдээ Богд хаант төрийн үе буюу 1914 оноос эхлэн авч үзэх нь зүйтэй гэсэн саналыг Монголын үлээвэр хөгжимчдийн холбооноос дэвшүүлсэн билээ.

Энэ нь Хаант Оросоос зэр зэвсэгтэй цуг Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн хүсэлтээр цэргийн үлээвэр хөгжим Монголд ирсэн, “монгол үндэсний сүлд дуу”-г Богдын торгон цэргийн үлээвэр найрал хөгжимчид анх эгшиглүүлсэн зэрэгтэй он цагийн хувьд тохирч байгаа болохоор цэргийн үлээвэр найрал хөгжмийн үүслийг энэ цаг хугацаагаар тогтох нь зүйтэй болов уу гэж судлаачийн хувьд үзэж байна.

Монголын хөгжмийн урлаг бол олон зуун жил хөгжин өвлөгдөж ирсэн ардын уламжлалт уран бүтээлээс гадна өрнө, дорно төдийгүй дэлхийн сонгодог хөгжмөөс суралцан, улмаар дэлхийн хөгжмийн урлагт өөрийн зохих байр сууриа эзэлсэн хөгжмийн соёл юм. Гэхдээ монголын сонгодог хөгжмийн соёл нь өрнийн олон орны адил олон зуун жилээр биш хэдхэн арван жилээр тооцогддог бөгөөд өнөөгийн цэргийн үлээвэр хөгжмийн түүхэн замнал ч бүтэн зууны нүүрийг үзэж амжаагүй байна.

Ардын засаг, Цэргийн яамнаас хувьсгалын дараа үеэс цэргийн урлаг, соёлын байгууллагийг шинээр эмхлэн зохион байгуулах талаар дэс дараатай олон арга хэмжээг авч байв. Тухайлбал, ардын хувьсгалын ялалтын дараа Монгол ардын хувьсгалт цэргийн дотор соёл урлаг хөгжүүлэх бодлого нь жанжин Сүхбаатарын боловсруулсан баримт бичигт тусгалаа олж байсныг Ардын хувсгалын 1 жилийн ойг тэмдэглэх тухай 1922 оны 7 сарын 29-нд гарсан Цэргийн яамны 20 тоот тушаалд “Дуу аялгуу дор сайн хүмүүсийг сонгож, нэгэн суман болгон дуу аялуулбаас зохино” [7.12] гэсэн баримтаас харж болно. Мөн Ардын журамт цэрэг нийслэл хүрээг чөлөөлсний дараа шинэ тулгар төр улсаа тунхаглахдаа Богдын торгон цэргийн хөгжмийг шинэ төрийн мэдэлд үлдээсэн байна.

1922 оны 4-р сард жанжин Д.Сүхбаатар Богдын торгон цэргийн хөгжмийн багш А.А.Кольцовын хамт Ардын цэргийн тэргүүн хороон дээр ирж “анхны хөгжмийн цэрэг”-үүдийг шалган авчээ. Т.Балданцэрэн, Намсрай, Санжжав, Самдан, Мишиг, Дашзэвэг, М.Даваа нарын 7 хүнийг хөгжмийн цэрэгт шалгаруулан авч сургаж эхэлсэн бөгөөд улмаар 1924 онд Богд гэгээнтэнийг таалал төгссөний дараа түүний торгон цэргийг татан авч цэргийн хөгжмийг өргөтгөснөөр цэргийн үлээвэр хөгжмийн хөгжин дэвжих зам эхэлжээ [8.11].

Цэргийн үлээвэр хөгжим нь ардын цэргийн дайчдын жагсаал, өглөө оройн тоо гэх мэт өдөр тутмын үйл ажиллагаанд эгшиглэх болж нийт ард түмний хүртээл болж эхэлжээ. Тухайлбал, Д.Сүхбаатарын цэргүүд үлээвэр найрал хөгжмийн сүрлэг аялгуун дор цэргийн үзүүлэх сургууль хийж ард түмэндээ толилуулж байжээ. Үлээвэр хөгжимтэй тоглолт нь өрнөдийн ард түмний дунд олон зууны туршид хэрэглэгдэж, хөгжиж ирсэн ч монголчуудын хувьд цоо шинэ зүйл байсан нь тодорхой.

XX зууны 50-иад оныг хүртэл мэргэжлийн хөгжмийн урлагийн суурь нь үлээвэр хөгжим байж монголын анхны мэргэжлийн хөгжимчин, удирдаач, багш-сурган хүмүүжүүлэгчид, хөгжмийн зохиолч, найруулга зүйн авъяастанууд төрөн гарах хөрс нь болсон байна. Орчин цагийн монголын дуу хөгжмийн урлагийн түүхэнд үлээвэр найрал

хөгжим чухал байр эзэлдэг бөгөөд чухам энэ хөгжмийн шууд нөлөөгөөр монголчууд өрнөдийн хөгжмийн онолын сэтгэлгээтэй анх танилцжээ.

Ийнхүү “үлээвэр хөгжим” нь нийт ард түмний хэрэгцээнд үйлчилэхээс гадна “Цэргийн үлээвэр хөгжим, цэргийн гуулин хөгжим” гэсэн тодотголтойгоор эх орны бахархал болсон эр цэргийн сүр хүч, золбоо хийморийг тодотгон монголын ард түмний сэтгэлд эрч хүч, эр зоригийг эгшиглүүлсээр ирсэн. Мөн монголын соёл, урлагийн түүхэнд болон монголын Зэвсэгт Хүчний түүхэнд чухал үүрэг гүйцэтгэж ирсний зэрэгцээ цэрэг дайчдаас тайван цагийн болон байлдааны үүрэг даалгавараа амжилттай биелүүлэх сэтгэл зүйн бэлтгэлийг хангах хэрэгт чухал хувь нэмэр оруулсаар ирсэн билээ. Тиймээс цэргийн үлээвэр хөгжмийн түүхгүйгээр монгол цэргийн түүх бичлэг, монголын соёлын түүх бүрэн төгс болж чадахгүй нь тодорхой юм.

Энэ салбарын уран бүтээлч хамт олны бүтээлч үйл ажиллагаа нь монголчуудын оюуны ертөнцөд баттай байр суурийг эзэлж чадсаныг тэдний уран бүтээлийн чанарын түвшин, мэргэжлийн өндөр ур чадвар батлан харуулж байна.

Тухайлбал, Зэвсэгт Хүчний Жанжин Штабын /ЗХЖШ/ Үлгэр Жишээ Үлээвэр Найрал Хөгжим, /ҮЖҮНХ/ Цэргийн Дуу Бүжгийн Эрдмийн Чуулгын /ЦДБЭЧ/ хамт олон оросын нэрт цэргийн жанжин В.Суворовын хэлснээр цог золбоотой маршийн аялгуугаараа “цэргийн жагсаалын сүр хүчийг хоёроос гурав дахин нэмээд” зогсохгүй, мэргэжлийн хөгжмийн урлагийн байгууллага гэдгээ баталж дотооддоо болон гадаадын олон оронд өөрсдийн авьяас билэг, мэргэжлийн ур чадварыг батлан харуулж, эх орондоо болон хилийн чанадад олон сайхан тоглолтыг хийж байна.

2000 оноос хойш ЦДБЭЧ Солонгос улсын “Хаврын баяр” наадамд удаа дараа оролцож “Алт, мөнгөн цом, Гран-При” шагналуудыг олон удаа хүртсэн. Өнгөрсөн жил 75 жилийн ойгоо тэмдэглэж нийслэлчүүдийнхээ сэтгэлийг сэргээж, мэлмийг баясгаж, сонорыг мялаасан чадварлаг тоглолтуудаараа ая эгшгийн мялаалга өргөсөн. Мөн ҮЖҮНХ-ийн хамт олон өнгөрсөн хавар БНСУ-ын тэнгисийн цэргийн командлагчийн ивээл дор Өмнөд Солонгосын Жэнь-Хайя хотод болсон олон улсын цэргийн үлээвэр хөгжмийн анхдугаар наадамд амжилттай оролцсон, намар нь ХБНГУ-ын нийслэл Берлин хотод болсон олон улсын цэргийн үлээвэр хөгжимчдийн XIII наадамд анх удаа маш амжилттай оролцсон зэрэг нь үүний хамгийн тод жишээ болж байна.

ЗХЖШ-ын ҮЖҮНХ, ЦДБЭЧ-ийн уран бүтээлч хамт олны үйл ажиллагаанаас гадна Зэвсэгт Хүчний цэргийн үлээвэр хөгжмийн хамт олны бүтээлч амжилтыг БХИС-ийн Цэргийн Хөгжмийн Сургуулийн сургалтын үйл ажиллагаанаас ч харж болно.

Мэргэжлийн өндөр зэрэгтэй, сонгодог хөгжим өндөр хөгжсөн дэлхийн олон орон оролцдог олон улсын наадмуудад манай цэргийн үлээвэр хөгжмийнхөн амжилттай оролцож тэнд оролцсон хамтлагуудтай эн зэрэгцэх уран бүтээлийг хийнэ гэдэг бол эдгээр уран бүтээлч хамт олон мэргэжлийн хувьд ямар түвшинд байгааг тодорхойлж болох үзүүлэлт билээ.

Ийнхүү орчин цагийн Монголын дуу хөгжмийн урлагийн түүхэнд үлээвэр найрал хөгжим чухал байр эзэлж өнөөдөр Монгол оронд өрнөдөөс нэвтэрсэн цэргийн үлээвэр найрал хөгжим нь монгол цэргийн жагсаалын сүр хүчийг илэрхийлж, батлан хамгаалах бүрэлдэхүүний нэгэн чухал хэсэг болоод байна.

#### Abstract

This article tells about a history of use wind music in military actions, about revival of the first wind orchestra in Mongolia, how was created a state hymn of Mongolia at Bogdo khan, about a role of a wind orchestra in the Mongolian culture and defensive business. Also it considers features of development of a military wind orchestra of Mongolia from the point of view of a history.

Key words: music, military music, state hymn, military brass band, Bogdo khan, defensive branch.

## II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

### Эш татсан ном зохиол, эх сурвалж

1. Б.Содном. Монгол дууны түүхээс. УБ 1960 он. 6, 7-р тал.
2. Бадрах. Монголын хөгжмийн түүх. УБ. 1960 он. 21-р тал.
3. Бадрах. Монголын хөгжмийн түүх. УБ. 1960 он. 29-р тал.
4. Дашдорж. Цоодол. “Ардын дуу хөгжмийн суу билэгтнүүд”. УБ 1970 он. 145-р тал.
5. С.Гангааням. Монголчууд тусгаар тогтнолоо хамгаалан тэмцсэн нь. /1911-1921/ УБ. 1993 он. 33-р тал
6. Монголын соёл урлаг судлал. УБ. 1999 он. Д.Цэдэв. Олноо өргөгдсөн хаант Монгол улс, түүний сүлд дууны тухай. 22, 25-р тал
7. Г.Ганбат “Цэргийн чуулга-70”
8. А.Жаргал. Д.Дамдиндорж. Зүрхэнд шингэсэн эгшиг. 1992 он. 11-р тал